

ДУХЫН БУУЦ I, II БИЧЭЭСИЙН ТУХАЙ

ШАБАН ДОГАН

*Измирийн Катин Чэлэби Их Сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн
Түрк хэл, Уран Зохиолын Тэнхимийн профессор*

Хураангуй: Руни үсгээрх Түрэгийн дурсгалд өмнө нь гарч байгаагүй Хятад сурвалжид Ch'e-pi хэмээн тэмдэглэгдэн үлдсэн хааны нэрийг “Духын бууц” бичээст тэмдэглэсэн байх бөгөөд Хятад хэлээрх Ch'e-pi гэх дуудлагыг эртний Түрэг хэлээр Çebiş хэмээн буулгажээ. Эртний Уйгур хэл болон Диванү Лүгэт-ит Түрк тольд анх тэмдэглэсэн, бусад бичээст тохиолдоггүй “baуa” гэх үг мөн бичээст гарч байна. Уг бичээсийн ойр орчимд сийлсэн Карлук, Басмилын аль нэгэнд хамаатай хэмээн үзсэн тамгыг Карлук тамга гэж тогтоож байна. Карлукууд 754 онд энэхүү бичээс байгаа газрыг орхин явсан гэсэн мэдээнд тулгуурлан “Духын бууц II” бичээсийг энэ үеэс өмнө сийлсэн гэж үзэж болно. Сийлэгч *ertimiz* (𐰽𐰺𐰍) хэрэг гэх үгийг бичихдээ /m/ /𐰽/ үсэг, (𐰽) үгийг бичихдээ /t/ /ᠲ/ үсгийг ашигласан нь бичээсийг харьцангуй эрт үед холбогдохыг гэрчилж байна.

Түлхүүр үг: Монгол нутаг дахь Түрэгийн бичиг, хадны бичээс, Духын бууц I, II бичээс

Keywords: Tureg inscriptions in Mongolia, Rock Inscription, Inscription of the Dukhyn Buuts I, Inscription of the Dukhyn Buuts II

Монголын өргөн уудам газар нутгаас жил бүр руни бичгийн шинэ дурсгалууд олдсоор байгаа бөгөөд эдгээр дурсгалыг нээн илрүүлснээр эртний түрэг хэлээрх бичгийн баримт хийгээд үгийн сан улам бүр баяжиж байна. Монгол улсын нутаг дахь руни үсгээрх бага дурсгалыг ихэвчлэн монгол судлаачид олж илрүүлэн холбогдох судалгаагаар монгол сэтгүүлүүдэд хэвлүүлж судалгааны эргэлтэнд оруулж байна. Тиймээс салбарын мэргэжилтнүүд эдгээр бичээсийн тухай анхны мэдээллийг монгол хэлээр хэвлэгдсэн судалгаагаар дамжуулан авдаг. Мөн бичээсийн уншлага, орчуулга, тайлбар сэлтийг эндээс үзэж танилцаж байна.

Гадаадын судлаачид бичээсийг олж илрүүлэн уншлага судалгаагаар монголоос өөр гадаад хэлээр хэвлэн нийтлэх нь цөөн юм. Энэхүү өгүүлэлд тухайлан авч үзсэн “Духын бууц I” бичээсийг Монгол улсын археологич Я.Цэрэндагва,

С.Далантай нар олж илрүүлэн ШУА-аас 2021 оны 12 дугаар сарын 15-16-ны хооронд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд анх танилцуулан шинжлэх ухааны эргэлтэнд оруулжээ. (Я.Цэрэндагва, С.Далантай, 2021) Энэхүү мэдээнд тулгуурлан миний бие тус бичээсийн анхны орчуулга, холбогдох тайлбарыг хийхийн хамт “Духын бууц II” бичээсийг 2022 оны 7 дугаар сарын 28-д шинээр олж илрүүлэн орчуулга, тайлбар хийж өөрийн саналаа дэвшүүлсэн болно. (Доган, 2022) Түүнчлэн дэд профессор Ю.Болдбаатарын хамт “Духын бууц I” бичээсийн талаарх судалгаагаа (Доган, Юндэнбат, 2023), мөн “Духын бууц II” бичээсийн талаарх өөрийн судалгаагаа Турк улсад, турк хэлээр хэвлүүлсэн билээ. (Доган, 2022)

Энэхүү өгүүллийн гол зорилго нь дээр нэр дурдсан хоёр бичээсийн орчуулга, судалгаагаа Монголын шинжлэх ухааны салбарын мэргэжилтнүүдэд хүргэх явдал юм. Тус өгүүлэлдээ өмнөх судалгаагаа үндэс болгохын хамт зарим алдаа мэдгийг хянан засав. Бичээст холбогдох тамга тэмдгийн зүйлийг энд авч үзээгүй болно.

“ДУХЫН БУУЦ I” БИЧЭЭС

Бидний тухайлан авч үзэж буй энэхүү бичээс, тамгануудыг Монголын археологич Я.Цэрэндагва, С.Далантай нар олж илрүүлсэн бөгөөд энэ тухайгаа ШУА-аас 2021 оны 12 дугаар сарын 15-16-ны хооронд зохион байгуулсан хуралд танилцуулан шинжлэх ухааны эргэлтэнд оруулжээ (Я.Цэрэндагва, С.Далантай 2021).

Судлаачид “Хангай говийн зааг дээр шинээр олж илрүүлсэн археологийн дурсгалууд: Духын бууц, Бүрдэн цохион хадны зураг, тамга, бичээсүүд” хэмээх илтгэлдээ Баянхонгор аймгийн Богд сумын нутаг дэвсгэрт орших “Духын бууц”, Өвөрхангай аймгийн Хайрхан сумын нутаг дэвсгэрт орших “Бүрдэн цохио” зэрэг газруудаас баримтжуулан авсан бичээс, хадны зураг, тамга тэмдгийг танилцуулсан байна.

“Духын бууц” нь Баянхонгор аймгийн Богд сумын төвөөс зүүн хойш 55 км, Авзага уулнаас хойноос урагш 7 км үргэлжилсэн “Олон овооны хүрэм”-ийн өргөн бэлчирийн дунд оршдог. Баримтжуулан авсан дурсгалуудын дотор томоохон хаданд сийлсэн эртний нүүдэлчдийнх бололтой нэгэн бичээс байсан нь анхаарал татдаг. Тус бичээс нь нийт 10 үсгээс бүрдэнэ. Бичээсийг томоохон хадны оройн хэсэгт тэгш гадаргуу дээр сийлсэн байна. Бичээсийн хажууд сэрээ хэлбэртэй нэгэн тамга бий. Хадны өмнө талын гадаргуу нь ташуу, цуурсан бөгөөд доод хэсэг нь хагарсан байна. Бүтэн хэвээр үлдсэн хадны дээд хэсэгт нум хэлбэртэй тамга болон сүүлт тамга сийлсэн байх бөгөөд дунд нь танихад бэрх нэгэн амьтны дүрслэл байна. Хадны хагарсан доод хэсэгт хоёр янгир сийлсэн харагдана. Бичээс бүхий хадны зүүн доод хэсэгт нэг могой тамга сийлжээ (Я.Цэрэндагва, С.Далантай 2021, 138).

Археологич Я.Цэрэндагва, С.Далантай нар уг судалгааныхаа хавсралт хэсэгт “Духын бууц” бичээсийн байгаа хад болон бичээсийн зургийг оруулсан байна (Я.Цэрэндагва, С.Далантай 2021, 141). Гэвч хавсралт дахь гэрэл зураг болон гар зурагт тулгуурлан бичээсийг уншихад бэрх байсан тул ШУТИС-ийн дэд проф.

Ю.Болдбаатартай холбогдож бичээсийн шаардлага хангасан тод гэрэл зураг байгаа эсэх, олж илрүүлсэн судлаачид бичээсийн эхийг хэвлүүлсэн эсэх, хэрвээ хэвлдэгдээгүй бол бидний зүгээс хэвлэн нийтэлж болох эсэхийг лавласан билээ. Дэд проф. Ю.Болдбаатар тухайн судлаачидтай уулзан шинэ гар зураг (Зураг 1) болон нэг ширхэг фото зургийн хамт авч бидэнд илгээн энэхүү бичээсийг хамтран уншиж судлахыг санал болгов. Ийнхүү бичээсийг уншиж тайлах ажил эхэлсэн боловч зарим үсэг тэмдэгт тодорхой биш байсан тул дахин баримтжуулах шаардлагатай болсон юм.

Бид 2022 оны 07 дугаар сарын 28-нд уг бичээсийн олдсон газарт очиж дурсгалын ойр орчмын тамга тэмдгийг баримтжуулж, өмнөх баримтанд тодорхойгүй, эргэлзээтэй байсан үсэг тэмдэгтийг дахин нягталж уншлага, орчуулгыг хийсэн болно.

“Духын бууц” бичээс нь дээр дурдсанчлан Монгол улсын Баянхонгор аймгийн Богд сумын төвөөс зүүн хойш 55 км, Авзага уулаас хойноос урагш 7 км үргэлжилсэн “Олон овооны хүрэм”-ийн өргөн амны дунд буюу $45^{\circ} 60' 86.8 \text{ N } 101^{\circ} 15' 94.7 \text{ E}$ солбицолд Духын бууц гэдэг газарт оршдог. Энэ бичээсийг өвөлжөө болгон ашиглаж байсан газарт ойролцоогоор хоёр метр өндөр хаданд сийлсэн байна. Нийт арван үсэг тэмдэгтээс бүрдэх тус бичээсийн зарим тэмдэгт цаг хугацааны явцад элэгдэн бүдгэрсэн учраас Я.Цэрэндагва, С.Далантай нарын хийсэн баримтжуулалт, гар зурагт (Зураг 1) тодорхой гараагүй бололтой. Бид өөрийн биеэр тус бүс нутагт очиж бичээсийг дахин баримтжуулав (Зураг 2). Нэг мөр бүхий бичээсийн эхлэл хэсгээс муруйсан хэсэг дэх тавдугаар үсэг хүртэл 11 см, зургадугаар үсгээс төгсгөл хэсэг хүртэл 12 см, нийт урт нь 23 см байна. Мөн үсгийн дундаж өндөр нь 5 см болно.

Руни бичээсийн эхийн хуулбар

Руни эх: DJ3DΔNϵYΓϕ

Үсгийн галиг: $b^2 \dot{l}^2 g^2 E b^1 y^1 n \dot{c} A y^1$

Үгийн галиг: bilge b(a)y (a)nᠴa (a)y

Монгол орчуулга: Билгэ (хүн) баян билээ. Тийнхүү өгүүл.

Тэмдэглэл:

Бичээсийг уншиж тайлсаны үр дүнд дараах зүйлийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Тус бичээст үг, холбоо үг зэргийг ялган зааглахад ямар нэгэн тэмдэгт ашиглаагүй байна. Мөн үсэг тэмдэгтийг Орхон түрэг хэлний сонгодог дурсгалын

уламжлалт бичлэгээр, зөв бичгийн дүрмийн дагуу бичсэн нь анхаарал татаж байна. (D), (ᠳᠰ), (Dᠰ), (ᠳᠰᠢᠬᠡ). Үүнээс үүдэн уг бичээсийг бичигч нь Хөх Түрэгийн бичгийн хэлний дүрмийг сайн мэддэг байсан хэмээн үзэж болно. Я.Цэрэндагва, С.Далантай нарын хуулбарт эх бичээсийн хоёр дахь тэмдэгтийг /iç/, /çi/ гэх нийлмэл үсэг гэж үзээд (•) байдлаар дүрсэлсэн байна. Бидний хийсэн судалгаагаар тэрхүү тэмдэгт нь байгалийн чулуун дээр уулаас байсан толбо болохыг олж тогтоосон бөгөөд түүний дээд хэсэгт бичээсийг сийлсэн нь судлаачдыг төөрөгдүүлсэн байж магадгүй хэмээн үзэж байна.

Судлаачдын (ᠸ) хэмээн буулгасан, Хөх Түрэгийн үсэг бичгийн тогтолцоонд хэлний үзүүрийн /g/ авиаг тэмдэглэсэн тэмдэгтийг бид (ᠬ) байдлаар хуулбарлан авсан билээ. Ижил авиаг тэмдэглэсэн нэг үсгийн адил бус хэлбэрүүд Хөх Түрэгийн бичгийн системд тохиолддог (Kormuşin 2017, 27).

Бичээс нь дөрвөн үг, хоёр өгүүлбэрээс бүрдэнэ. Үүнд, *bay* хэмээх тэмдэг нэр туслах үйл үгийн тусламжтайгаар өгүүлэхүүн гишүүний үүрэг гүйцэтгэж, ерөнхий одоо цагийн гуравдугаар бие, ганц тоо заах нөхцөл авсан байна. Харин нөгөө өгүүлбэрийн өгүүлэхүүн нь захирах төлөвийн хоёрдугаар бие, ганц тоо заасан хэлбэр болох *ay-* үйл үгээр илэрчээ. (Bilge bay eür. Ança ay(gil). Орхон түрэг хэлэнд үйл үгийн хоёрдугаар бие ганц тоо заах захирах хэлбэр *-gil, -gil* бүтээвэр авч утгыг илүү эрчимчүүлдэг ч захирах өгүүлбэрт энэхүү бүтээврийг авахгүй байж болно.

“Otuz (Tatar), Tokuz Oguz begleri, boduni! Bu sabimin edgüti eşid, katıgdi tıñla (K1) (Ercilasun 2016, 544).” Бидний тухайлан авч үзсэн бичээст “*ança ay*” хэмээн уншсан нь эртний түрэг хэлний өгүүлбэрийн бүтэцтэй зөрчилддөхгүй юм. Эртний Түрэг хэлний үеийн бичгийн баримтанд үндсэн туслах үйл үгээр үйлийн цаг, биед хамаатуулах утгыг өгүүлбэрт тэг хэлбэрээр илрүүлсэн жишээ цөөнгүй тохиолддог билээ. Хэрэв бидний ийнхүү уншин тайлбарлах нь зөв бол туслах үйл үгийн хойно байгаа бүтээвэрүүд тэг хэлбэрээр илрүүлсэн нь хоёр дахь өгүүлбэрийн өгүүлэхүүнтэй авиа ижилсүүлэн санаагаа товч тодорхой илэрхийлэх зорилготой байжээ гэж үзэх боломжтой.

“ДУХЫН БУУЦ II” БИЧЭЭС

2022 оны 7 дугаар сарын 28-нд “Духын бууц I” бичээсийг газар дээр нь үзэж танилцахаар очих үед Баянхонгор аймгийн Богд сумын төвөөс зүүн хойш 55 км, Авзага уулнаас хойноос урагш 7 км үргэлжилсэн “Олон овооны хүрэм”-ийн өргөн амны дунд орших “Духын бууц” хэмээн нэрлэх өвөлжөөний ард байх нэгэн хадан дээр Түрэгийн руни үсгээрх гурван мөр бичээс байгааг олж илрүүлсэн билээ.

Энэхүү бичээсийг Духын бууц өвөлжөөний ард, тэгш гадаргуутай, 60 см урт, 35 см өргөн хадан дээр сийлсэн бөгөөд байршлын солбицол нь 45° 60' 86.8 N 101° 15' 94.7 E болно. Гурван мөр, нийт 23 үсэг тэмдэгтээс бүрдэнэ.¹ Үсгийн өндөр нь 5-6 см. Тус бичээсийг сийлсэн хадан дээр мөн нэг тамга сийлсэн бөгөөд бичээсийг тамганы хажууд бичжээ. Шамашев нар гараа сунган тэнгэр өөд өргөсөн байдалтай

¹ Бичээсийн нийт үсгийн тоо нь үсэг тэмдэгтийн элэгдэн холцорсноос үүдэн өөр өөр байж болно.

хүний дүрс мэт тамга нь “Бөмбөгөр”-ийн бичээст буй бөгөөд энэ тамганы хувилбар тамганууд нь Карлук юм уу Басмил овгийн аль нэгэнд хамаарах боломжтой хэмээн тэмдэглэжээ. (2010: 140,161) Бөмбөгөрийн бичээсийг сийлсэн чулуун дээр энэхүү тамганы олон хувилбар бий. “Духын бууц II” бичээсийн хажууд байх тамга нь Бөмбөгөрийн дурсгалын хамгийн дээд талын, бусад тамганаас арай том хэмжээтэй тамгатай ижил байна. Уг бичээсийг уншиж, тайлахад энэ тамгыг мөн харгалзан үзсэнээ тэмдэглэх нь зүйтэй.

Бидний үзэж байгаагаар бичээсийг тэгш талбайд багтаахын тулд сийлбэрчин зарим тэмдэгтийг харилцан адилгүй бичсэн бөгөөд өөр хэн нэгэн засвар хийсэн байх боломжтой юм. Түүнчлэн зарим үсэг тэмдэгтийн элэгдэж холцорсон зэргээс шалтгаалан энэхүү бичээсийг өөр өөрөөр унших магадлалтай. Иймд тус бичээсийг ялгаатай байдлаар тайлан унших нөхцөл шалтгааныг өгүүллийн төгсгөлд “Тэмдэглэл” хэсэгт оруулсан болно.

Бичээсийн эх ²

Руни үсгээрх эх:

1. 𐰇𐰏 𐰃𐰏 𐰏𐰏 𐰏𐰏
2. 𐰏𐰏𐰏
3. 𐰏𐰏𐰏 𐰏𐰏 𐰏𐰏

Үсгийн галиг:

1. $\zeta(e)b^2I\zeta (e)b^2r\ddot{w} on^1 (o)k^1$
2. r^2t^2mz
3. $by^1A At k^1r^1l^1k^w$

Үгийн галиг:

1. $\zeta(e)bi\zeta (e)b(i)r\ddot{u} on (o)k$
2. $(e)rt(i)m(i)z$
3. $b(a)y(a) at karluk$

Орчуулга:

1. Чебиш (Хаан) (улсыг) удирдаж байх үед Он Ок (овгийн дотор)
2. байлаа бид.
3. Түрүүхэн нэр (маань) (овгийн нэр маань) Карлук (болов).

Тайлбар:

а. Мөрийн дараалал

Бид уг бичээсийн 1, 2-р мөрийг баруунаас зүүн тийш, 3-р мөрийг доороос дээш хандуулан бичсэн хэмээн үзэж байна. Сийлбэрчин эхлээд тамгаа зурж, дараа нь хадны доод хэсгээс эхлэн баруунаас зүүн тийш эхний мөрийг бичээд дараа нь хоёрдугаар мөрийг доороос дээш чиглэн сийлж эхний мөр болон тамга хоёрын хоорондох зайд сүүлийн мөрийг багтаан бичсэн бололтой. Бидний үзэж байгаагаар доод хэсэгт бичсэн мөр болон тамга хоёрын хооронд бичсэн гуравдугаар мөрийн төгсгөлд (l^1) үсгийг бичээд сүүлчийн (k^1) үсэг багтаагүйн улмаас доор нь бичсэн байна. Энэ талаар Карлук хэмээх үгийн тайлбарт тодорхой өгүүлэх болно.

² Эхийн гэрэлтүүлэг цаасанд буулгасан хуулбараас авсан зургийг хавсралтанд оруулав. (Зураг 3)

6. Үг хэллэгийн тайлбар

Тухайлан авч үзэж буй бичээст гарах зарим үг хэллэгийг тус бичээсийг унших, орчуулах, бичлэгийн онцлогийг тодруулах үүднээс тусгайлан авч үзэх нь зүйтэй юм.

Çebiş (ᠬᠡᠪᠢᠰ): Эртний түрэг бичээст “ямааны үр төл, ишиг” гэсэн утгаар нэг удаа тохиолддог “y(e)ti ç(e)b(i)ş(i)m-e : (e)s(i)z-e : eş(i)m-e : (e)s(i)z-e (Ye 51/3, Şirin 2016, 310). Гэвч дээрх бичээст хам сэдвийн хүрээнд утга тохирохгүй болох нь тодорхой харагдаж байна. Ye 51 дурсгалд “çb²ş” хэмээн бичигдсэн үг нь “Духын бууц” бичээст хоёрдугаар үеийн эм, уйтан эгшгийг нь бичин (ᠬᠡᠪᠢᠰ) хэлбэрээр тохиолдож байна. Түрэгийн руни бичгийн үсэгзүйн тогтолцоонд эхний үеэс хойшхи үеийн эр, эм уйтан /l/, /i/ эгшгийг ерөнхийдөө бичдэггүй уламжлалтай. Гэвч эдгээр эгшгийг зарим тохиолдолд бичиж болно (Tekin 2016, 34). Тиймээс зөв бичгийн дүрмийн хувьд зөрчилдөх зүйлгүй юм. Энд шийдэх зүйл бол бичлэгийн зөрүү биш үгийн утгын асуудал бөгөөд дээр дурдсанаар “ишиг” гэх утга агуулгад тохирохгүй байна. Энэ нь бидний санал болгож буй уншлага, орчуулгыг дэмжих үндэслэл болно хэмээн санана.

“Çebiş” хэмээх үг нь Ахмет Бижан Эржиласуны “635-640 онд Алтайн нурууны хойд хэсэгт амьдарч байсан Түрэгийн нэг язгууртан (Ercilasun 2016, 235)” гэж дурдсан, мөн хятад сурвалжид *ch'e-pi* гэж тэмдэглэсэн оноосон нэр мөн болно. *Ch'e-pi* - тэй холбоотой Эртний Тангийн түүхэнд тэмдэглэсэн мэдээл сонирхол татаж байна. “Өмнө *Chen-kuan*-ы хаанчлалын дунд үед (635-640), Түрэгүүдийн захиргаанд байсан өөр нэг овгийн тэргүүлэгч *Çebi(ş)* гэдэг хүн байжээ. Тэр бол ашина овгийн хүн байв. Хаан болон сууж байлаа. Түүний цэрэг нь Алтайн нурууны хойд хэсэгт байв. (Тоган, 2006: 203)” Тоган энэхүү мэдээний талаар тайлбарлахдаа *ch'e-pi* хэмээх нэрийн талаарх Эжседийн саналыг эш татжээ. Эжседи судалгаандаа *ch'e-pi* гэх үгийг *ch'e-pi (shih)* байдлаар сэргээн тэрхүү оноосон нэрийг *çebiş* байх боломжтой гэж үзжээ. (Тоган, 2006: 203-204) Эржиласун (2016), Тоган (2006) нарын судалгаанд тухайн үгийг *Çebiş* хэмээн үзсэн нь Эжседи-ийн саналтай нийлж байгаа билээ.

Ахмет Ташагыл *Ch'e-pi* хааныг Хөх Түрэгийн “A-shih-na” овгийн нэгэн язгууртан байсан бөгөөд 638 оны үед Алтайн нуруу орчимд ноёрхлоо тогтож байсан талаар дурджээ. Мөн 630 оны эхээр Ил хаан доройтон хятадад олзлогдсоны дараа Түрэгүүд түүнийг хаан болгох саналтай байсан ч хятадуудын дэмжлэгээр хүчирхэгжиж ханлиг улсаа зарласан Сир Тардуш нарт шахагдан энэ үйл хэргээ бүтээж чадаагүй болохыг, Сир Тардуш нар ухаантай, сайн удирдагч *Ch'e-pi*-гээс айн түүнийг алахаар шийдсэн боловч *Ch'e-pi* үүнийг мэдээд өөрийн овгийн хамт Алтайн нурууны хойд талд ирж, тэндээ хүчирхэгжин өөрийгөө хаанаар зарлаж, баруун зүгт Карлукууд, хойд зүгт Киргизүүд түүнд захирагдсан болохыг, дараа нь Сир Тардуш нарыг ялж Хятадтай улс төрийн харилцаа тогтоохыг оролдсон хэдий ч хожим нь хятадын башир арганд автсан овог аймгууд түүнийг орхиж ганцаараа үлдэн 650 онд хэдэн зуун морьт цэргийн хамт Алтайн нуруу руу зугатан одсоныг, эцэст нь шархдаж *Ch'ang-an* тийшээ

хөөгдөн амьд үлдэхийн тулд тэндээ амьдрахаас өөр аргагүй болсон тухай тус тус тэмдэглэжээ (Taşağıl, 1999, II: 39-40) Ташагыл-ын өгүүлснээр Карлукууд нь Çebiş хааныг дагасан тухай мэдээ эртний Тангийн түүхэнд мөн дурдагдсан байдаг. Үүнд “Баруун талд Карлукууд байв, хойд талд Киргизүүд байв; (Çebiş) бүгдийг өөртөө захируулав (Togan, 2006: 205)” хэмээжээ.

Ebirü (ЧТХ): Руни бичгийн дурсгалд “1. Эргэх 2. (нэг газар) тойрон явах. 3. улсыг удирдах (Şirin, 2016: 726)” гэсэн утгаар тохиолдох ebir- үйл үгийн нөхцөлдүүлэн холбох хэлбэр гэж үзэж байна. “удирдаж байхад, удирдахдаа” хэмээсэн утгатай “ebirü” үйл үгийн бичлэг болон утгын тухайд дараах зүйлийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Үгийн төгсгөл дэх дайвар үгийг бичихэд хэрэглэсэн (Ч) үсэг ба руни бичгийн /r/ үсэг хороондоо төстэй байна. Эртний Түрэг хэлний /ö/, /ü/ эгшигийг тэмдэглэсэн үсэг, ялангуяа Енисейн бичээст тохиолдох хэлбэрийг “Духын бууц II”-г хэрэглэсэн нь тодорхой байна. (ö, ü авиаг тэмдэглэсэн үсгийн хувилбаруудыг Şirin, 2006, 38-аас лавлана уу).

Энэхүү үгийг орчин цагийн түрк хэлнээ хөрвүүлэхдээ дээр дурдсан утгуудаас “ilî yönetmek, çekir çevirmek (улсыг удирдах, татаж эргүүлэх)” утгыг сонгосон бөгөөд нөхцөл үйл үгийн бүтээвэр авч “удирдаж байхдаа” гэсэн утгыг илэрхийлжээ. -U эгшиг нөхцөлдүүлэн холбох бүтээвэр-ийн утгыг илрүүлдэг ч бичээст энэхүү утгаар хэрэглэгдээгүй учир ихээхэн эргэлзээтэй юм. Энэ талаар Габайн хэлэхдээ “үгийн төгсгөлд орсон нөхцөл үйл үгийн -р бүтээврээр цагийн утгын ялгааг илрүүлж болно. -р нь хугацааны хувьд урьтаж хэрэгжсэн, нөгөө нь нэгэн зэрэг хэрэгжсэнийг илтгэнэ. Atıñ ata-yu, kut kiw özin kelti (ТТ I 116) ‘нэрийг нь дуудангуут, saadet өөрөө ирэв’ (Gabain, 2007: 86)” хэмээн тэмдэглэсэн нь бидний тухайлан авч үзэж буй үгийн хувилалыг тайлбарлахад чухал баримт болж байна. Ebir- нь “улсаа удирдах” гэх үйл үгэнд -U нөхцөлдүүлэн холбох бүтээвэр авч үйл хэргийн нэгэн зэрэг хэрэгжсэнийгилэрхийлсэн тул “удирдах байхдаа” гэж ойлгох нь зүйтэй.

On Ok (л)᠎): Эртний Түрэг бичээст “Түрэгийн хаант улсын баруун гарыг бүрдүүлж байсан арван овгийн түрэг аймаг (Şirin 2016, 736)” –ийн нэр болох энэхүү үгийг бичихдээ (ok, uk, k, ko, ku) авианы онцлогоос шалтгаалан нэг үеийг тэмдэглэдэг (᠋) үсийг ашиглаагүй нь анхаарал татаж байна. Бичээсийг бичигч этгээд тухайн үгийн эхний хоёр үсгийг (᠋) уламжлалт бичлэгийн дагуу бичсэн боловч (ok) гэх үеийн (᠋) үсгийн оронд /k1/ (л) -ийг сонгожээ. On Ok овгийн нэрийг руни бичгийн дурсгалд (᠋) нийлмэл үсгийн оронд /k1/ (X)-ийг бичсэн нь зөвхөн Духын бууц II дурсгал биш юм. Бидэнд мэдэгдэж байгаагаар Кочкор -1, 2, 3, 4, 5, 7, 11, 16, 17, 21, 22, 23 (Alimov 2014, 163-182) зэрэг бичээст мөн адил /k1/ (л)-ээр тэмдэглэсэн байдаг. Проф. Алимов энэхүү үсгийн бичлэгийн талаар “Үгийн хоёр дахь уруулын эгшгийг бичээст бичээгүй нь сийлэгч үүнийг нэг үг хэмээн үзсэнтэй холбоотой байж болох юм. (Alimov 2014, 164-165)” гэж өгүүлжээ. Энэхүү саналыг Талат Текин “Эхний үедээ уруулын эгшигтэй үсгийн дараагийн үе дэх уруулын эгшгийг нь ихэвчлэн бичдэггүй (Alimov 2014, 165; Tekin 1968, 37)” хэмээн дэмжсэн байна.

Эртний Түрэг бичээст “Түрэгийн хаант улсын баруун гарыг бүрдүүлж байсан арван овгийн түрэг аймаг (Şirin 2016, 736)” гэж үзсэн *On Ok* угсаатны нэр анх 635 оны дараа үеэс дурдагдах болжээ. “Баруун хаант улсыг яг арван овог аймагт хувааж, *On Ok* хэмээн нэрлэх болсон нь Ишбара Төлис хааны үе буюу 635 оны дараа болсон үйл явдал юм. Ийнхүү хувааж овог бүрийн тэргүүнд нэг ноён байсан бөгөөд тэднийг шад гэж нэрлэдэг байв. Нийт арван шад байжээ. Шад болгонд нэг суман бэлэглэсэн (Ercilasun 2016, 204).” Уг хэрэг явдлыг Хятад сурвалжид баруун Түрэгүүд бичсэнээр “*Şa-po-lo T'ie-li-şi* хаан есдүгээр *çeng-kuan* (635) онд ураг барилдахаар таван зуун морь өргөн барьж Хятадын ордонд бичиг илгээв. Түүнийг найрсгаар хүлээн авсан хэдий ч гэрлэхийг зөвшөөрсөнгүй. Хожим нь *T'ie-li-şi*-ийн ханлиг арван овог аймагт хуваагдаж овог болгоны тэргүүнд нэг ноён байв. Эдгээрийг арван шад гэж нэрлэдэг байв. Шад бүрт нэг суман бэлэглэв. Тийм учраас тэднийг “*on oklar*” (арван суман) гэж нэрлэжээ. Үүнээс гадна *арван суман нь* тус бүр таван сумантай баруун, зүүн гарт хуваагджээ. Зүүн гар нь таван *Tu-lu* овгоос бүрдэх бөгөөд тус бүрийн тэргүүн нь *ç'o* (*çur*) байлаа. (Chavannes 2007, 41-42).”

Ertimiz (𐰽𐰺𐰸𐰸): Уг бичээс дэх *On Ok* нэр үгийг эртний түрэг хэлний *er*-туслах үйл үгийн тусламжтайгаар үйл өгүүлэхүүн өнгөрсөн цагийн нэгдүгээр бие, олон тооны (-*ti-miz*) нөхцөлөөр хэлбэржсэн байна. Энэ үгийн бичлэг, уншлага нь тодорхой бөгөөд “Арван суман байлаа, бид” хэмээн орчууллаа. Туслах үйл үгийн цаг болон биед хамаатуулах нөхцөл авсан хэлбэр нь руни бичгийн зөв бичих зүйн уламжлалтай тохирч байгаа бөгөөд бусад бичээст олонтаа тохиолддог. *Biz az ertimiz* (𐰽𐰺𐰸𐰸), *yabız ertimiz* (𐰽𐰺𐰸𐰸) ‘Бид цөөн байлаа, Бид хүнд хэцүү байдалтай байлаа (BK D 32, Ercilasun 2016, 575).

Baya (𐰽𐰺𐰸): Өнөөг хүртэл эртний Түрэгийн бичээст хараахан гараагүй *baya* хэмээх үг анх удаа эртний Уйгур хэл болон Диван-ү лугатит Түрк-т тохиолдоно. Энэ үгийг EDPT-д “recently; in the immediate past” (энэ өдрүүд, ойрын үед) гэсэн утгатай болохыг тэмдэглэжээ (Clauson 1972, 384). Эртний Уйгур хэлний гарлын толь бичигт “хараахан, дөнгөж сая, түрүүхэн” гэж тайлбарласан байна. (Wilkens 2021, 152). Хэдийгээр Диван-и лугатит Түрк ДЛТ-д тэмдэглэсэн ч толгой үг байдлаар тусгайлан тайлбарлаагүй ажээ. “*baya ok keldim*” (Үнэн хэрэгтээ би саяхан ирсэн) (Ercilasun, Akkoynlu 2014, 17).

Хадны элэгдэж холцорсон байдал, сийлбэрчний бичлэгийн онцлог, /y/ үсгийн доторх хэсэг холцрон унасан байдал зэргээс үүдэн уг бичээсийн хоёр дахь мөрийн эхний үг болох *baya* гэх үгийг уншиж тайлахад бэрхшээлтэй болжээ. Иймд энэхүү үгийг тусгайлан авч үзэх хэрэгтэй.

At (𐰽𐰺): Эртний Түрэг хэлний бичгийн дурсгалд “1. нэр, 2. цол, 3. өргөмж нэр, овгийн нэр” (Şirin 2016, 721) гэсэн утгаар тохиолддог энэхүү үг бичлэг болон утгын хувьд ямар нэгэн эргэлзээ байхгүй. Сийлбэрчин эртний Түрэгийн бичээсийн эгшигтэй (𐰽𐰺) болон эгшиггүй (𐰽) хоёр бичлэгийн эгшигтэй хэлбэрийг сонгосон байна. Талат Текин “Үгийн эхний /a/ ба /e/ эгшгийг бичигт гол төлөв тэмдэглэдэггүй. ... үгийн эхний урт /ā/ эгшгийг Күл Тэгин, Билгэ Хааны бичээст

цөөн тохиолдолд зөвхөн *āç* ‘нээ-, *āç-* ‘өлсөх’, *āt* ‘нэр, цол’ гэх мэт үгсэд бичдэг (2016, 29-30)” гэж үгийн эхний эгшгийг бичсэнийг урт эгшигтэй холбон тайлбарлажээ.

Karluk (↓↑Чл):

Бичээст Карлук хэмээн уншигдах үгийн бичлэгийн хувьд анхаарал татах хоёр зүйл байна. Нэгдүгээрт бичигч этгээдийн /l¹/ -ийг тэмдэглэсэн хэмээн үзэж буй (l) үсэг; хоёр дахь нь эртний Түрэгийн руни бичигт (ok-uk-k-ko-ku) авиаг тэмдэглэдэг үет үсэг (↓) –ийн сэртэн хэсэг доошоо биш дээшээ (↑) хандсан явдал юм. Бичээсийн эхийг гэрэлтүүлэх цаасандээр буулган үзэхэд (l) үсэгтэй холбоотой хэд хэдэн асуудал бидний анхаарлыг татлаа. Эртний Түрэгийн руни бичигт /l¹/ авиаг тэмдэглэдэг үсгийн сэртэн хэсэг нь доод талд, зүүн тийш (↓) хандсан байдаг бол Духын бууц II дурсгалд сэртэн хэсэг нь дээд талдаа байна. Цэгтэй төстэй хоёр ховил гаргасан (сийлэх үед доош гулсаж өмнөх үсэгтэй нийлэхээс сэргийлэх зорилгоор сийлсэн гэж үзэж байна) бөгөөд баруун тийш хандсан, мөн үсгийн үндсэн хэсгийг ч гэсэн бага зэрэг баруун тийш налууулж бичсэн харагдана.

Цэгүүдийг үл анзаарснаас үүдэн тухайн үсгийг /n¹/ авиа хэмээн андуурч болох боловч бидний *On Ok* гэж уншсан үгэнд (л᠋᠋) /n¹/-ийг яг нуман хэлбэртэй бичсэн байна. Харин /l¹/ хэмээн үзэж буй үсэг үүнээс ялгаатай юм. Бидний үзэж байгаагаар сийлбэрчин үсэг тэмдэгтийг баруун тийш бага зэрэг налуу бичсэн шалтгаан нь өмнө тайлбарлан бичсэн *ertimiz* гэж уншиж буй (Ч᠋᠋᠋᠋) гэх үгэнд орсон (/m/ /᠋/ ve /᠋/ /᠋/) үсгийг хольж солихоос сэргийлэх зорилготой юм. Уг бичээсийн гэрэл зургийг ашиглан хийсэн гар зургаас (Зураг 3) тодруулан харвал холбогдох үсгийг босоо сийлэн бичих тохиолдолд гэмтээх магадлал өндөр байжээ. Үсгийн сэртэн хэсэг нь дээд талдаа зүүн тийш хандсан байгаа нь мөн эргэлзээ төрүүлж байна. Үсгийн ийм бичлэг руни бичгийн үсгийн тогтолцоонд /l¹/ -ийг тэмдэглэх байдал зөвхөн энэ дурсгалд биш Енисейн бичээсүүдэд ч мөн тохиолддог. (Şigin 2016, 39-ээс лавлана уу).

Тус бичээст (ok-uk-k-ko-ku) үеийг тэмдэглэсэн (↓) үсэг тэмдэгтийн сэртэн хэсэг нь дээшээ харсан (↑) хэлбэр Түрэгийн үеийн руни үсгээрх дурсгалд олонтаа тохиолдоно. Энэхүү үе тэмдэглэсэн үсэг нь мөрийн төгсгөлд багтаагүй тул эхний мөр ба хоёрдугаар мөрийн хооронд сийлжээ. Сийлбэрчин дээрх үе үсгийг тухайн мөрийн сүүлийн үсгийн доорх хоосон зайд сийлсэн байна. Бид бичигч этгээд уулаас бичихээр төлөвлөж байсан үгээ (магадгүй *bolti*) талбайд багтахгүй байсан учир бичилгүйгээр эх сэдвийн хүрээнд утгыг ойлгох боломжтой хэмээн санаад орхисон байх магадлалтай гэж таамаглаж байна.

Чебиш хааны үед *Reit'ing* (Бешбалык)-ийн баруун хойд хэсэгт, Алтайн нурууны баруун биед, өөрөөр хэлбэл Тарвагатайн бүс нутагт байсан Карлукуудаас (Togan 2006, 205) салсан хэсэг Карлукууд анх Түрэг улсад харьяалагдаж байсан бол хожим II Түрэг улсыг мөхөөсөн аймгууд (Басмил, Уйгур, Карлук)-д багтаж байжээ. Энэ аймгийн холбоо “Тухайн үед (745-757) Уйгуруудын удирдлагаар Төв Азийн нутгаас баруун зүг, Он Ок –ийн нутагт хүрч

байжээ (Golden 2002, 114). Өтүкэнд үлдсэн Карлукууд (Гурван Карлук), Уйгурын II хаан Моюн Чорын үед (747-759) Киргиз, Чик, Түргиш, Басмил овог аймгуудтай холбоо тогтоож Моюн Чорын эсрэг бослого гаргав (753). 754 онд Карлук, Басмыл хоёр Уйгурын цэрэгт ялагдаж, Карлукуудаас амьд үлдсэн хүмүүсийг Түргишийн нутаг руу явуулжээ. (Şirin, 2010, 70).” Энэ үйл явдлыг Тариатын бичээст (G 3-4) “Гурван Карлук муу санаа өвөртлөн зугтан одсон бөгөөд баруун зүгийн Он Ок(нар)-тай нэгдэв (Aydin 2011: 46-47)” Шинэ Ус-ны бичээст (K 11) “Гурван Карлук нар мууг санаж зугтан одов. Тэд Баруун зүгт Он Ок нартай нэгдэв (Aydin 2011: 67)” гэж бичжээ.

ДУГНЭЛТ

Уг бичээс байх Монгол улсын Баянхонгор аймаг нь гурвалсан холбоонд байсан Карлукуудын нутаглаж байсан бүс нутгийн нэг юм. Энэхүү бичээст тэмдэглэсэн Карлук угсаатны нэр болон Карлук эсвэл Басмил овгийн нэгэнд холбоотой хэмээн үзэж буй тамгыг төв хэсэгт сийлсэн нь уг бичээс Карлук нартай холбоотой гэдгийг гэрчилж байна. Мөн тус бичээсийг сийлсэн он өмнө тайлбарласан түүхэн хэрэг явдлаас үзэхэд 754 оноос өмнө байх боломжтой. Бичээсийн хажууд буй тамга ч гэсэн Карлук тамга юм. Энд нэгдүгээр хаант улсын үед (630-681) хаант улсыг дахин нэгтгэх гэж оролдсон Чебиш болон Баруун Түрэгийн хаант улстай ийн нэр дурдагдсан болохыг онцлон үзэх нь зүйтэй. Бидний бодлоор сийлбэрчин эдгээр нэртэй холбоотой овог аймгийн нөхцөл байдлыг өгүүлэх, энэхүү түүхийг онцлон дурдах зорилгоор энэ бичээсийг бичиж сийлжээ. Иймд уг бичээсийг сийлэх үед Карлук овгийн харьяанд (эсвэл харилцаа холбоотой) байсан овог нь Чебишийн хаанчлалын үед Он Ок овгийн дотор байсан бололтой. Энэ нь Чебишийн захиргаанд байсан бөгөөд “Баруун талд Карлукууд байсан, хойд хэсэгт Киргизүүд байсан билээ; (Чебиш) бүгдийг нь өөртөө захируулсан билээ (Togan 2006, 205)” хэмээн дурдсанаас үзэхэд Карлукуудын дунд байгаагүй ажээ. Бидний уншлага тайлбар зөв бол уг бичээст хааныг цолгүйгээр зөвхөн нэрээр нь дурдаж байгаа нь түүнийг үл таашаасан, магадгүй дайсан мэтээр үзсэний илрэл юм. Сийлбэрчин, тэд ямар нэгэн байдлаар Түрэг улстай холбоотой овог биш гэсэн мэдээллийг өгөхийг зорьсон болов уу. Чебиш хааны үед ч, түүнээс дараах Түрэгийн ноёрхлыг ч хүлээн зөвшөөрөөгүй байна. Тиймээс “*ç(e)biş (e)b(i)rü on (o)k (e)rt(i)m(i)z b(a)y(a) at karluk*” гэж уншиж буй энэ бичээсийг “*Чебиш хаан улсыг захирч байх үед Он Ок байлаа бид. (Он Ок нарт харьяалагдаж байлаа бид) Түрүүхэн (өмнө нь) нэр (маань) Карлук (болов)*” хэмээн орчуулах саналтай байгаагаа тэмдэглэе.

Тус бичээст гарах *baуа* гэдэг үгийг тэмдэг нэр үг хэмээн үзэж, бичээс дэх “*Чебиш хаан улсыг захирч байх үед Он Ок байлаа бид. (Он Ок нарт харьяалагдаж байлаа бид) Эхний (өмнөх) нэр (маань) Карлук (болов)*” гэж ойлгох боломжтой боловч энэ тохиолдолд бичээсийг сийлэгч этгээд өөрсдийгөө Карлук гэж нэрлэх боломж үгүй юм. Түүнчлэн энэ бичээст холбогдох Карлук тамгыг тайлбарлахад

төвөгтэй байдал үүсгэнэ. Тус бичээсийг сийлэх үед Он Ок нар баруун зүгт байсан түүхийг ч харгалзан үзэх хэрэгтэй.

Дүгнэн өгүүлбэл,

а. Руни үсгээрх Түрэгийн дурсгалд өмнө нь гарч байгаагүй Хятад сурвалжид Ch'e-ri хэмээн тэмдэглэгдэн үлдсэн хааны нэрийг “Духын бууц” бичээст тэмдэглэсэн байх бөгөөд Хятад хэлээрх Ch'e-ri гэх дуудлагыг эртний Түрэг хэлээр Çebiş хэмээн буулгажээ.

б. Эртний Уйгур хэл болон Диванү Лүгэт-ит Түрк тольд анх тэмдэглэсэн, бусад бичээст тохиолдоггүй “бауа” гэх үг мөн бичээст гарч байна.

в. Уг бичээсийн ойр орчимд сийлсэн Карлук, Басмилын аль нэгэнд хамаатай хэмээн үзсэн тамгыг Карлук тамга гэж тогтоож байна.

д. Карлукууд 754 онд энэхүү бичээс байгаа газрыг орхин явсан гэсэн мэдээнд тулгуурлан “Духын бууц II” бичээсийг энэ үеэс өмнө сийлсэн гэж үзэж болно. Сийлэгч *ertimiz* (𐰽𐰺𐰏𐰍) хэрэг гэх үгийг бичихдээ /m/ /𐰽/ үсэг, (𐰽) үгийг бичихдээ /t'/ /𐰽'/ үсгийг ашигласан нь бичээсийг харьцангуй эрт үед холбогдохыг гэрчилж байна.

Тэмдэглэл:

Бага бичээсийг сийлэн бичихэд хадны гадаргуун талбай хязгаарлагдмал байдгаас олон үсэг, үгийг багтаахад хүндрэлтэй, зарим сийлбэрч зөв бичих зүйн мэдлэг дутмаг байдгаас үүдэн гаргасан алдаа мадаг энэ төрлийн бичээсийг уншиж тайлахад хүндрэл учруулдаг байна. Иймээс уг бичээсийн шинэ уншлага, орчуулгыг хийж сийлэгчийн зүгээс гаргасан алдаа мадгийг тайлбарлан судлаачидтай санал солилцохыг хүссэн болно.

Энэхүү бичээсийн эхний мөрөн дэх *ebirü* (𐰽𐰏𐰍) гэх үгийн бичлэгтэй холбоотой хоёр зүйл анхаарал татаж. Үүнд, нэгдүгээрт дээр дурдсан *ebir-* үйл үгэнд залгасан –U нөхцөл үйл үгийн бүтээвэр руни бичээст /r¹/-ийг тэмдэглэдэг үсэгтэй ижил төстэй (магадгүй адилхан) байгаа явдал юм. Энэ бичлэгийн хэлбэрийг эртний түрэг бичгийн системд /ö/, /ü/ авиаг, ялангуяа Енисейн бичээст тэмдэглэж байсантай холбон тайлбарлалаа. Энэ тайлбар тодорхой боловч Түрэгийн руни бичгийн үсгийн тогтолцоонд /r¹/ үсгийг голдуу тэмдэглэдэг /ʃ/ тэмдэгтийг сийлбэрч мөн бичээсийн “карлук” гэх угсаатны нэр (𐰽𐰏𐰍) –д хэрэглэсэн нь эргэлзээ төрүүлж байна. Бичлэгийн энэ онцлогийг бичигч этгээд Түрэг руни бичгийн үсгийн тогтолцоонд /ö/, /ü/ авиаг тэмдэглэдэг (ʃ) хэлбэрийг мэддэггүй, Енисейн бичээст хэрэглэдэг хэлбэрийг сонгон бичсэн гэж тайлбарлаж болно. Бичээст /ö/, /ü/ авиа байхгүй учир харьцуулан тайлбарлах боломжгүй юм. Сэдвийн хүрээнд нэмж тэмдэглэхэд сийлбэрч /r¹/ авиаг тэмдэглэсэн үсгийг босоо (ʃ), /ü/-г тэмдэглэсэн үсгийг баруун тийш бага зэрэг налуу (ʃ) байдлаар бичжээ. (зураг 3).


Ebirü (𐰽𐰏𐰍) гэх үгийн бичлэгийн анхаарал татаж буй өөр нэг зүйл бол уул үгийн бүтэц дэх /r²/ (ʃ) үсэг ба *ertimiz* (𐰽𐰺𐰏𐰍) гэх үгийн /r²/ (ʃ) хоёр нь нэг үсгийн өөр хэлбэрүүд болох явдал юм. Нэг бичээст хоёр өөр хэлбэр ашигласан нь сонирхолтой боловч энэ нь хадны бичээст түгээмэл тохиолддог жишээ

юм. Ялангуяа Алтайн уулархаг бүсийн бичээсүүдэд (Biçigtu-boom 5 - A 55) (Конкобаев 2015, 169) тохиолдоно.


Бичээсийн хамгийн эргэлзээтэй хэсэг бол гурав дахь мөрийн эхний үг болох *baγa* (ᠨᠳᠳ) юм. Энэ хэсгийг бичсэн хад ихээхэн эвдэрсэн, сийлбэрчний алдаа мадаг, мөн бичээсийг сийлсэн хадны гадаргуугийн байгалийн шинж чанараас шалтгаалж уншиж тайлбарлахад ихээхэн хүндрэлтэй байна. /b¹/ (ᠳ) үсгийн хувьд эргэлзээ байхгүй, харин дараагийн үсэг болох /y¹/ (ᠳ) –г олон төлөөр тайлбарлах боломжтой. Үсгийн босоо шугамыг бичих талбайн төв хэсэгт хаданд үүссэн байгалийн нүх таарчээ. Сийлбэрч үсгийг сийлэхдээ ашигласан нарийн үзүүртэй хэрэгсэл нь тэрхүү нүх рүү хальгарч үүнээс үүдэн тэнд сэртэн тавьсан хэлбэр үүссэн харагдана. Босоо зураасаар холбож зурагдах нөгөө зураасын дээд ба доод хэсэгт маш жижиг нүх буй. Үсгийн энэ зураасаар бичээст нэр дурдагдсан Карлук угсаатны нэрийн сүүлчийн үсэг *ok* тэдэгтийн дээд хэсгийн сэртэн нийлсэн байдалтай байна. Энэхүү нийлсэн хэсгийн зургийг компьютерт хэсэгчлэн шалгаж үзсэний үр дүнд *ok* (↑) үсгийн дээд хэсгийн голд үсгийн энэ хэсэг нийлж /r¹/ үсэгтэй төстэй болсон байна. Үүнийг анзаарсан сийлбэрч *ok* тэмдгийн дээд хэсгийг илүү тод харагдуулахын тулд үсгийн сэртэн хэсгийг доод талд нь бичжээ. Сийлбэрч бичээсийг (эсвэл үг)-ийг бичиж дуусгаад /y¹/- ийн дараах үсгийн дээд сэртэн хэсгийг мартсанаа ойлгож засч залруулах үүднээс сэртэнг баруун тийш, гэхдээ үсгийг эвдэхгүйн тулд бүтэн шугамаар биш цэгээр гүйцээн бичсэн байна. Үүнтэй ижил засварыг Карлук угсаатны нэрэнд мөн хийсэн бөгөөд холбогдох хэсэгт тусгайлан өгүүлсэн болно.

Хавсралт

Зураг



Зураг 1. Духын бууц I бичээс (Цэрэндагва, Далантай нар)



Зураг 2. Духын бууц I бичээс (Шабан Доган)



Зураг 3: Духын бууц II бичээсийн Гэрэлтүүлэг цаасанд буулгасан байдал



Бичигт-боом 5 (А 55) бичээс (Конкобаев 2015, 169)

Номзүй

1. Alimov, R. (2014), Tanrı Dağı Yazıtları, Eski Türk Runik Yazıtları Üzerine Bir İnceleme, Kömen Yayınları, Konya.
2. Aydın, E. (2011). Uygur Kağanlığı Yazıtları, Kömen Yayınları, Konya.
3. Chavannes, E. (2007), Çin Kaynaklarına Göre Batı Türkleri (Çev. Mustafa Koç), Selenge Yayınları, İstanbul.
4. Clauson, Sir G. (1972), An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish, Oxford, Clarendon Press.
5. Doğan Ş., (2022), Moğolistan’da Yeni Keşfedilen Dukhiin Buuts II Yazıtı, Türk Kültürü, 15, 23-41
6. Doğan Ş., B. Yundenbat (2023), Dukhiin Buuts Yazıtı Üzerine, Doğumunun 80. Yılında Prof. Dr. Ahmet Bican Ercilasun Armağanı, Türk Dil Kurumu Yayınları, Ankara.
7. Ercilasun A. B. (2016), Türk Kağanlığı ve Türk Bengü Taşları, Dergâh Yayınları, İstanbul.
8. Ercilasun, A. B., Akkoyunlu, Z. (2014), Kâşgarlı Mahmud, Divânu Lugâti’t-Türk, Giriş-Metin-Çeviri-Notlar-Dizin, Türk Dil Kurumu Yayınları, Ankara.
9. Gabain, A. V. (2007), Eski Türkçenin Grameri (Çev: Mehmet Akalın) (5. Baskı), Türk Dil Kurumu Yayınları, Ankara.
10. Kıdırali, Darhan, Gaybullah, Babayar (2015), TÜRK BENGÜ TAŞI: Şiveet-Ulaan Damgalı Anıtı, Astana: Uluslararası Türk Akademisi yayınları, «Gılım» Yayınevi.
11. Kormuşin, İgor Valentinoviç (2017), Yenisey Eski Türk Mezar Yazıtları (Metinler ve İncelemeler), (Çeviren: Rysbek Alimov), Türk Dil Kurumu Yayınları, Ankara.
12. Samashev, Z., Bazilhan, N., Samashev S. (2010), Drevnetyurkskiye Tamgi – Köne Türk Tangbaları - Ancient Turkic tamga-signs, Almatı: Abdi Yayınları.
13. Şirin, H. (2006), Başlangıcından Günümüze Türk Yazı Sistemleri, Akçağ Yayınları, Ankara.
14. Şirin, H. (2010), “Bömbögör Yazıtı: Bir Türk Kunçuyunun Mezar Taşı”, Dil Araştırmaları, Sayı 7, s. 62-73.
15. Şirin, H. (2016), Eski Türk Yazıtları Söz Varlığı İncelemesi, Türk Dil Kurumu Yayınları (Ankara).
16. Taşağıl, A. (1999), Gök-Türkler II (Fetret Devri 630-681), Türk Tarih Kurumu Yayınları, Ankara.

17. Tekin, T. (2016), *Orhon Türkçesi Grameri*, Türk Dil Kurumu Yayınları, Ankara.
18. Togan, İ., Kara G., Baysal, C. (2006), *Çin Kaynaklarında Türkler, Eski T'ang Tarihi (Chiu T'ang-shu)*, Türk Tarih Kurumu Yayınları, Ankara.
19. Wilkens, J. (2021), *Handwörterbuch des Altuigurischen, Altuigurischen–Deutsch–Türkisch*, (Eski Uygurcanın El Sözlüğü, Eski Uygurca–Almanca–Türkçe), Akademie der Wissenschaften zu Göttingen.
20. Заагаас шинээр илрүүлсэн археологийн дурсгалууд: Духын бууц, Бүрдэн Цохиогийн хадны зураг, тамга тэмдэг, *Монголын Археологи-2021, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтэл*, 138-143, Улаанбаатар.
21. Конкобаев, К., Нурдин Усеев, Негизбек Шабданалиев (2015), *Атлас Древнетюркских Письменных Памятников Республики Алтай*, Международная Тюркская Академия, «Гылым» баспасы, Астана.
22. Ц. Баттулга (Tsend, Battulga) (2020), *Монголын руни бичгийн бага дурсгал, Монголын Археологийн Өв –ХII, хуудас 118-119*, Улаанбаатар.
23. Я. Цэрэндагва, С. Далантай (2021), *Хангай говийн заагаас шинээр илрүүлсэн археологийн дурсгалууд: Духын бууц, Бүрдэн цохиогийн хадны зураг, тамга тэмдэг, бичээс, Монголын Археологи-2021, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, 138-143, Улаанбаатар.